









## АГУУЛГА

	Бүртгэлтэй ажилгүйчүүд
	Эрүүл мэнд
	Банк
	Төсөв
	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ
	Хөдөө аж ахуй
	Аж үйлдвэр
	Цахилгаан холбоо

## **Аргачлалын тайлбар**

### **Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

## Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

## Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

$I_{ct}^L$  -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

$P_{it}$  -'i' барааны тайлант үеийн үнэ,

$P_{io}$  -'i' барааны суурь үеийн үнэ,

$Q_{io}$  -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

### **Хөдөө аж ахуй**

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

### **Нэгдсэн төсөв**

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

### **Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж хауй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

### **Хөдөлмөр**

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2016 оны 11 дугаар сарын байдал)

## Бүртгэлтэй ажилгүй иргэн


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 11 сарын байдлаар 832 байгаагийн 56 хувь нь буюу 466 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 37 хүнээр буюу 4.7 хувиар өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингөөр нь авч үзвэл 266 нь дээд, 35 нь тусгай дунд, 78 нь техник мэргэжлийн, 368 нь бүрэн дунд, 48 нь суурь, 30 нь бага, 7 нь ямар ч боловсролгүй байна хүмүүс байна.


### Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингөөр, 2016 оны 11 сарын эцэст, дүнд эзлэх хувиар



### Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд, жил бүрийн 11 сарын байдлаар



### Бүртгэлтэй ажилгүй иргэд, 11 сарын байдлаар насны бүлгээр



2014 I-XI

2015 I-XI


2016 I-XI

## Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 11 сарын байдлаар 1098 эх амаржиж 1099 хүүхэд мэнд төрлөө.

Эхний 11 сарын байдлаар нялхасын эндэгдэл 18 тохиолдол болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 12.5 хувиар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс өөрчлөгдөөгүй байна.

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**




**Эндсэн хүүхэд, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**



Цочмог халдварт өвчин 903 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 525 ихсэж 2.4 дахин нэмэгдсэн байна. Халдварт өвчлөл нэмэгдэхэд улаан бурхнаар өвчлөгчид өнгөрсөн оны мөн үеэс 636 буюу 17.2 дахин, салхин цэцгээр өвчлөгчид 63 буюу 3.9 дахин, гар хөл амны өвчин 21 буюу 4.2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**



## Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2016 оны 10 дугаар сарын эцэст 63.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 1.0 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар буурчээ.


**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг**

Үзүүлэлт	2016	
	IX	X
<b>Мөнгөний нийлүүлэлт M2</b>	<b>64763.7</b>	<b>63750.7</b>
Сарын өөрчлөлт, хувиар	2.8	-1.6
<b>Нийт хадгаламж</b>	<b>55167.3</b>	<b>53892.14</b>
Сарын өөрчлөлт, хувиар	2.5	-2.3
<b>Төгрөгийн хадгаламж</b>	<b>54851.4</b>	<b>53199.8</b>
Сарын өөрчлөлт, хувиар	2.7	-3.0
<b>Валютын хадгаламж</b>	<b>315.9</b>	<b>692.4</b>
Сарын өөрчлөлт, хувиар	-26.8	2.2 дахин

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 1432.2 сая төгрөг болж, өмнөх сарынхаас 520.3 сая төгрөг буюу 1.6 дахин өсчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 10 дугаар сарын эцэст 85.1 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 0.8 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 10 дугаар сарын эцэст 1.3 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.5 хувийг эзэлж байна. Чанаргүй зээл 2016 оны 10 дугаар сарын эцэст 1.6 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 17.0 сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.9 хувийг эзэлж байна.


**Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг**




## Төсвийн орлого

Орон нутгийн төсөвт нийт 52 тэрбум 463.4 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 89.7 хувиар, үүнээс татварын орлого 4 тэрбум 250.0 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 81.0 хувиар биелүүлсэн байна. Татварын бус орлого 48 тэрбум 213.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 29 тэрбум 441.5 сая, орон нутгийн хөгжлийн сангийн орлогоос 5 тэрбум 671.8 сая, улсын төсвөөс 9 тэрбум 16.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

### Төсвийн орлогын бүтэц, мянган төгрөгөөр 2016 оны I-XI сард




### Төсвийн орлогын бүтэц, хувиар 2016 оны I-XI сард




## Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 81.4 хувийг зарцуулав. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 90.8 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 89.2 хувь, бараа үйлчилгээ бусад зардлын 57.4 хувийг тус тус зарцуулсан байна.

### Төсвийн зарлагын бүтэц, хувиар 2016 оны I-XI сард



### Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016-10	2016-10	2016-10	2016-10
		2010-12	2015-10	2015-12	2016-09
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>154.6</b>	<b>101.9</b>	<b>103.3</b>	<b>100.6</b>
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	143.5	100.3	104.7	100.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	221.5	99.8	99.8	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	163.0	104.3	103.8	101.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	146.2	104.1	104.1	103.7
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	154.4	106.9	105.4	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	118.7	100.0	100.0	100.0
Тээвэр	12.2	136.3	97.8	98.3	99.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	96.0	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	110.6	99.4	99.4	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	393.6	109.1	109.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	192.5	103.5	103.5	103.5
Бусад бараа, үйлчилгээ	4.1	140.3	98.6	98.6	100.0

Хэрэглээний үнийн ерөнхий индекс 2016 оны 11 дүгээр сарын байдлаар өмнөх оны жилийн эцсээс 3.3 хувиар өссөн харагдаж байна.

**Махны дундаж үнэ:** 2016 оны 12-р сарын 10-ны байдлаар үхрийн цул махны үнэ өснөх сарынхаас 16.6 хувь, хонины махны үнэ өмнөх сарынхаас 3.3 хувь, ямааны махны үнэ 19.4 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад хонины махны үнэ өөрчлөлтгүй, үхрийн цул мах, ямааны махны үнэ 10.0-10.7 хувиар буурсан байна. 2016 оны 12-р сарын 10-ны байдлаар 1 кг хонины мах дунджаар 3500 төгрөг, үхрийн цул мах 4500 төгрөг, ямааны /ястай/ мах 2500 төгрөгийн үнэтэй байна.




## Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2016 оны 11-р сард аймгийн төв болох Есөнбулаг суманд үхрийн шир 15.0 мян.төг, адууны шир 40.0 мян.төг, хонь ямааны арьс 3.0 мян.төг, хонины ноос 700 төг, ямааны ноолуур 50.0 мян.төг байна.


## Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны 1184.1 мянган хээлтэгч малын 1068.5 мянга буюу 90.2 хувь нь эхний 11 сард төллөсөн байна. Эм ямааны 90.4 хувь, эм хонины 92.7 хувь, ингэний 48 хувь, үнээний 78 хувь, гүүний 78 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 98.4 хувь буюу 1052.7 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийхээс 115.6 мян буюу 0.3 хувиар өссөн байна.

### Төллөсөн хээлтэгч, сумаар, 2016 оны эхний 9 сард




### Бойжуулсан төл, төрлөөр, жил бүрийн эхний 11 сард




Том малын зүй бусын хорогдол 2016 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд 29.3 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийхээс 18.4 мянга буюу 2.6 дахин өссөн байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 489, үхэр 766, тэмээ 135, хонь 6830, ямаа 21144 байна. Нийт хорогдлын 23.3 хувийг хонь, 72 хувийг ямаа эзэлж байна. Өвчнөөр хорогдсон мал 2016 оны эхний 9 сард 983 болж, өмнөх оны мөн үеийнхээс 41-р буюу 4.4 хувиар өсчээ.

### Зүй бусаар хорогдсон том мал



### Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 2016 оны эхний 11 сард




## Газар тариалан

Үр тариа 525.3 тн, төмс 633.1 тн, хүнсний ногоо 468.7 тн, тэжээлийн ургамал 1479 тн, эмийн ургамал 10 тн, жимс жимсгэнэ 75.1 тн, хужир шүү 1837 тн-ыг тус тус хурааж, байгалийн хадлан 3697.9 тн, гар тэжээл 236.2 тн-ыг бэлтгээд байна.

## Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 11 сард 10 тэрбум 677.4 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 14.1 хувиар өслөө. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 44 хувийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, 28 хувийг дулаан эрчим хүч үйлдвэрлэл, 11 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 9 хувийг нүүрс олборлолт, 8 хувийг усан хангамж тус тус эзэлж байна.


### Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, 11 сарын байдлаар, салбараар




## Цахилгаан холбоо компани

Суурин телефон цэгийн тоо 759, холбооны газрын орлого 200.4 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 140.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Интернэтийн үйлчилгээний нэг цэгийн 20-н суудалтай ажиллаж интернэтээр дунджаар 5.2 мянган хүнд үйлчилжээ.

### Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг




### Суурин утасны цэгийн тоо




## 2016 оны X-XII сарын цаг агаарын урьдчилсан төлөв

**Арванхоёрдугаар сард.** Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж Говь-Алтайн нутгаар 9-16 градус хүйтэн байдаг(1 дүгээр зураг).




1 дүгээр зураг. 12 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)

Энэ сард агаарын дундаж температур Говь-Алтайн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас 0,5-1,0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй (2 дугаар зураг).




2 дугаар зураг. 12 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв

Уур амьсгалын дунджаар Говь-Алтайн нутгаар 1-4мм цас ордог. (3 дугаар зураг)




3 дугаар зураг. 12 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)

Энэ сард Говь-Алтайн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цасорох төлөвтэй. (4 дүгээр зураг).




4 дүгээр зураг. 12 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан төлөв

**Нэгдүгээр сард.** Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж Говь-Алтайн хойд хэсгээр 18-23 градус, бусад нутгаар 11-17 градус хүйтэн байдаг (**5 дугаар зураг**).




5 дугаар зураг. 1 дүгээр сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)

Энэ сард агаарын дундаж температур Говь-Алтайн нутгаар дээрх дунджийн орчим байх төлөвтэй (**6 дугаар зураг**).




6 дугаар зураг. 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв

Уур амьсгалын дунджаар Говь-Алтайн нутгаар 2 мм хүртэл цас ордог (**7 дугаар зураг**)




7 дугаар зураг. 1 дүгээр сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)

Энэ сард сард Говь-Алтайн нутгаар дээрх дунджийн орчим цас орох төлөвтэй (**8 дугаар зураг**).




8 дугаар зураг. 1 дүгээр сард орох хур тунадасны урьдчилсан төлөв

**Хоёрдугаар сард.** Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн өмнөд хэсгээр 6-14 градус, бусад нутгаар 15-20 градус хүйтэн байдаг (**9 дүгээр зураг**)




9 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)

Энэ сард агаарын дундаж температур Говь-Алтайн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, бусад нутгаар дээрх дунджийн орчим байх төлөвтэй(10 дугаар зураг).




10 дугаар зураг. 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв

Уур амьсгалын дунджаар Говь-Алтайн нутгаар 1.5мм хүртэл цас ордог(11дүгээр зураг).



11 дүгээр зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)

Энэ сард Говь-Алтайн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй( 12 дугаар зураг).



12 дугаар зураг. 2 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан төлөв

**ХӨДӨЛМӨР  
LABOUR**

**БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст**

**NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшингээр	By educational level	2012.XII	2013.XII	2014.XII	2015.XII	11-нàð	
						In November 2015	2016
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>840</b>	<b>1214</b>	<b>1241</b>	<b>1044</b>	<b>795</b>	<b>832</b>
Үүнээс: эмэгтэй	of which:female	540	669	699	547	434	466
Дээд боловсролтой	Higher education	325	259	327	252	221	266
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	50	481	477	72	55	35
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	53	37	37	81	62	78
Бүрэн дунд	Upper secondary school	246	287	270	483	344	368
Суурь	Compulsory secondary school	106	96	87	112	75	48
Бага	Primary school	43	45	34	35	28	30
Боловсролгүй	Uneducated persons	17	9	9	9	10	7

**БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, насны бүлгээр, 2016 оны 11 сарын эцэст**  
**NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of November 2016**

Cap Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	Үүнээс: насны бүлгээр of which:by age group											
			15-24	эмэгтэй female	25-34	эмэгтэй female	35-44	эмэгтэй female	45-59	эмэгтэй female	55-59	эмэгтэй female	60+	эмэгтэй female
I	925	486	171	83	394	207	209	119	121	66	21	5	9	6
II	901	485	160	75	368	201	215	126	127	71	22	6	9	6
III	1045	604	165	90	434	235	264	171	146	92	27	13	9	3
IV	998	586	150	85	425	232	242	159	145	93	27	14	9	3
V	954	562	158	91	401	220	229	151	132	84	25	13	9	3
VI	878	530	162	100	335	188	206	137	140	88	24	13	11	4
IX	814	456	174	97	308	169	180	113	122	66	21	8	9	3
X	831	465	166	95	316	176	189	116	128	67	23	8	9	3
XI	832	466	143	79	317	177	201	126	140	73	22	8	9	3

**АЖИЛГҮЙЧҮҮД, 2016 ОНЫ 11 САРД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ХҮН**  
**NUMBER UNEMPLOYED AND NEWLY REGISTERED PERSONS, in the 11 month of 2016**

Сар Month	Ажилгүйчүүдийн тоо, 11-р сарын эцэст			11-р сард шинээр бүртгүүлсэн ажилгүй хүн		
	Number of unemployed, at the end of 11 months			Number of unemployed newly registered in the 11 months		
	2015	2016	$\frac{2016\%}{2015}$	2015	2016	$\frac{2016\%}{2015}$
I	1176	925	78.7	279	0	0
II	1196	901	75.3	309	138	44.7
III	1100	1045	95.0	154	562	3.6 дахин
IV	1112	998	89.7	194	196	101.0
V	1094	954	87.2	330	46	13.9
VI	1175	878	74.7	292	255	87.3
IX	757	814	107.5			
X	729	831	114.0			
XI	795	832	104.7			

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР /зөвхөн аймагт бүртгүүлсэн ажилгүйчүүд/**  
**NUMBER OF UNEMPLOYED, by som**

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2012.XII	2013.XII	2014.XII	2015.XII	11-р сар in November		
						2015	2016	$\frac{2016\%}{2015}$
Есөнбулаг	Yesunbulag	326	271	488	284	202	381	188.6
Алтай	Altai	10	27	11	40	19	11	57.9
Баян-Уул	Bayan-Uul	22	19	12	22	16	40	2.5 дахин
Бигэр	Biger	54	53	23	56	23	34	147.8
Бугат	Bugat	48	22	33	26	15	22	146.7
Дарив	Darib	39	44	32	47	56	12	21.4
Дэлгэр	Delger	43	25	29	45	19	47	2.4 дахин
Жаргалан	Jargalan	15	18	26	33	23	8	34.8
Тайшир	Taishir	2	9	10	17	15	15	100.0
Тонхил	Tonhil	26	32	38	68	12	21	175.0
Төгрөг	Tugrug	40	37	18	37	18	18	100.0
Халиун	Haliun	20	21	16	35	25	24	96.0
Хөхморьт	Huhmorit	16	15	12	15	12	30	2.5 дахин
Цогт	Tsogt	61	61	40	73	13	59	4.5 дахин
Цээл	Tseel	53	12	22	37	25	15	60.0
Чандмань	Chandmani	35	44	16	75	21	34	161.9
Шарга	Sharga	14	19	27	46	16	33	2 дахин
Эрдэнэ	Erdene	16	39	11	25	19	28	147.4
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other		446	373	63	246		
<b>ÄĬ</b>	<b>TOTAL</b>	<b>514</b>	<b>943</b>	<b>1237</b>	<b>1044</b>	<b>795</b>	<b>832</b>	<b>104.7</b>

**ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**  
**PUBLIC HEALTH OF POPULATION**

№	Сумын нэр	Soum	Төрсөн эх <i>Women who gave births</i>		Эхийн эндэгдэл <i>Maternal Deaths</i>		Төрсөн хүүхэд <i>Births</i>		Нялхасын эндэгдэл <i>Infant mortality</i>		1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл <i>Under-five mortality</i>		Нийт нас баралт <i>Deaths</i>		Эмнэлэгт нас баралт <i>Deaths</i>	
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	294	273			298	274	5	4			19	22	8	6
2	Алтай	<i>Altai</i>	4	4			4	4	0	0	0		1	4		1
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	8	1			8	1	0	0	0		4	5		
3	Бигэр	<i>Biger</i>	5	3			5	3	0	0	0		2	4		
4	Бугат	<i>Bugat</i>		1				1	1	0	0		5	3	3	1
5	Гуулин	<i>Gulin</i>		1				1	0	0	0			1		
5	Дарив	<i>Darib</i>	3	1			3	1	0	0	0		3	2	1	2
6	Дэлгэр	<i>Delger</i>	5				5		0	0	0		4	5	1	1
7	Жаргалан	<i>Jargalan</i>							0	0	0					
8	Тайшир	<i>Taishir</i>							0	0	0		2	1	1	
8	Тонхил	<i>Tonhil</i>	3	3			3	3	0	1	0		2	3	1	1
9	Төгрөг	<i>Tugrug</i>	2	3			2	3	0	0	0			6		4
10	Халиун	<i>Haliun</i>	1	1			1	1	0	0	0		4	4		1
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>		2				2	0	0	0		4	2	1	1
11	Цогт	<i>Tsogt</i>	1	1			1	1	0	0	0		4	4	1	2
12	Цээл	<i>Tseel</i>	3	4			3	4	0	0	0		3	2		1
12	Чандмань	<i>Chandmani</i>	3				3		0	0	0		1	3	1	1
13	Шарга	<i>Sharga</i>							0	0	0		2	5	1	
14	Эрдэнэ	<i>Erdene</i>	2				2		0	0	0		2	2		
15	Баянтоорой	<i>Bayantoroï</i>		1				1	0	0	2	0	2	3	1	1
<b>22</b>	<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>334</b>	<b>299</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>338</b>	<b>300</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>64</b>	<b>81</b>	<b>20</b>	<b>23</b>

Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд <i>Infectious Diseases</i>		Үүнээс: Of which:													
			БЗХӨ STID				Заг хүйтэн <i>Gonorrhea</i>	гепатит <i>Hepatitis</i>		сүрьеэ <i>Tuberculosis</i>		Улаан бурхан		бусад <i>Other</i>		
			трихомоназ <i>Trichomoniasis</i>		тэмбүү <i>Syphilis</i>			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015
2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	
<i>Yesunbulag</i>	64	104	5	4	14	18	19	7	2	2	4	7		53	20	13
<i>Altai</i>	2	10			1	9			0	0				1	1	0
<i>Bayan-Uul</i>	9	4			6	3	1	1	1	0					1	0
<i>Biger</i>	0	0							0	0					0	0
<i>Bugat</i>	0	1				1			0	0					0	0
<i>Gulin</i>	0	0							0	0					0	0
<i>Darib</i>	4	16			2				1	0		1		15	1	0
<i>Delger</i>	2	3				2.0	2		0	0				1	0	0
<i>Jargalan</i>	2	2			1		1		0	1				1	0	0
<i>Taishir</i>	3	0							0	0					3	0
<i>Tonhil</i>	4	8			4	3		1	0	0				4	0	0
<i>Tugrug</i>	4	1			4				0	0				1	0	0
<i>Haliun</i>	1	1			1	1			0	0					0	0
<i>Huhmorit</i>	2	1			1	1			0	0					1	0
<i>Tsogt</i>	6	1	1			1	1		0	0					4	0
<i>Tseel</i>	2	6		1	1	3		2	0	0					1	0
<i>Chandmani</i>	2	2			1	1		1	0	0	1				0	0
<i>Sharga</i>	3	2			2		1	1	0	0		1			0	0
<i>Erdene</i>	1	24					1		0	0				24	0	0
<i>Bayantoroi</i>	1	1							0	0	1	1			0	0
<b>Total</b>	<b>112</b>	<b>187</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>38</b>	<b>43</b>	<b>26</b>	<b>13</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>10</b>	<b>0</b>	<b>100</b>	<b>32</b>	<b>13</b>

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хэргийн ангилал, төрлөөр  
NUMBER OF COMMITTED OFFENCES, by classification and types of offences

October 10, 2016

Хэргийн төрөл		Types of offences	2015 III улирал	2016 III улирал	2016 III 2015 III * %
Санаатай хүн амь		Attempted murder	1	0	0.0
Болгоомжгүй хүн амь		Manslaughter	0	0	0.0
Хүчин		Rape	5	2	40.0
Дээрэм булаалт		Robbery and mugging	1	1	100.0
Танхай		Assault	10	7	70.0
ББМБГУчруулах гэмт хэрэг		Inflicted injury to someone's body	61	57	93.4
Хулгайн гэмт хэрэг:		Theft	39	44	112.8
Тээврийн		Transportation	5	2	40.0
Үүнээс:	хэрэгсэл	Орон байрны			
	хулгай	Burglary in a dwelling	31	34	109.7
	Малын хулгай	Cattle theft	3	8	2 дахин
	Бусад хулгай	Other theft	0	0	0.0
Байгаль ХЖЭсрэг гэмт хэрэг		Crimes against environmental protectoin	0	1	1 дахин
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг		Economic crimes	0	0	0.0
Өмчийн	Тээврийн ХХАБАЖЭ гэмт хэрэг	Crimes against the rules of safety of traffic and use of motor vehicles	10	16	160.0
	Залилан	Fraud	2	2	100.0
	Албан тушаалын	Malfeasance crimes	0	0	0.0
	Бусад хэрэг	Other crime	23	11	47.8
<b>Бүх гэмт хэрэг</b>		<b>Total crime</b>	<b>152</b>	<b>141</b>	<b>92.8</b>
Учрал		chance	0	0	0.0
Согтуугаар		Drunk people	59	57	96.6
Үүнээс::	үйлдсэн хэрэг	Group of people	14	8	57.1
	Бүлэглэн үйлдсэн хэрэг				
	Онц хүнд гэмт хэрэг	Grave	1	2	2 дахин
	Хүнд гэмт хэрэг	Minor	15	7	46.7
Хохирол /сая төг/		Total	219.4	303.7	138.4
	Бүгд	reparation of damages	128.3	166.3	129.6
	Хохирол нөхөн төлөлт	Number of persons died	4	8	2 дахин
Гэмт хэргийн улмаас		Number of persons minor, serious	77	86	111.7
	Хүнд, хөнгөн гэмтсэн хүний тоо	precedence loser	6	13	2 дахин
	Урьд шийтгүүлсэн хүний тоо	rouser undetected	16	9	56.3
	Илрээгүй хэрэг	Crime detection rate	57%	76.9%	134.9
	Илрүүлэлтийн хувь	caption people	141	12	8.5
	Баривчлагдсан хүн	to invigorate people	588	485	82.5
	Саатуулагдсан хүн	Forfeit a driving license	205	114	55.6
	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдасан	Theft concerned	166	164	98.8
Гэмт хэрэгт холбогдогч:					
	Эмэгтэй	Female	17	18	105.9
Үүнээс:	Хүүхэд	Children	7	8	114.3
	Ажил мэргэжилгүй	Unemployed	67	69	103.0

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, сумаар  
NUMBER OF COMMITTED OFFENCES, by sum

October 10, 2016

№	Сум	Soum	2015 III	2016 III	Зөрүү тоо	$\frac{2016 \text{ III}}{2015 \text{ III}}$	*100%
1	Алтай	<i>Altai</i>	2	0	-2		0.0
2	Баян-Уул	<i>Bayn-Uul</i>	2	3	1		150.0
3	Бигэр	<i>Bugat</i>	2	2	0		100.0
4	Бугат	<i>Biger</i>	7	7	0		100.0
5	Дарив	<i>Dariv</i>	2	0	-2		0.0
6	Дэлгэр	<i>Delger</i>	7	6	-1		85.7
7	Жаргалан	<i>Jargalan</i>	2	4	2		2 дахин
8	Тайшир	<i>Taishir</i>	4	5	1		125.0
9	Тонхил	<i>Tonhil</i>	4	2	-2		50.0
10	Төгрөг	<i>Tugrug</i>	3	3	0		100.0
11	Халиун	<i>Khaliun</i>	2	3	1		150.0
12	Хөхморьт	<i>Khukhmorit</i>	7	3	-4		42.9
13	Цогт	<i>Tsogt</i>	4	4	0		100.0
14	Цээл	<i>Tseel</i>	7	1	-6		14.3
15	Чандмань	<i>Chandmani</i>	2	3	1		150.0
16	Шарга	<i>Sharga</i>	1	4	3		0.0
17	Эрдэнэ	<i>Erdene</i>	6	3	-3		50.0
18	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	88	88	0		100.0
19	Бусад аймаг	<i>Other aimag</i>	0	0	0		0.0
	<b>ДҮН</b>	<b>Total</b>	<b>152</b>	<b>141</b>	<b>-</b>		<b>92.8</b>



II. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сарын эцэст

LOANS OUTSTANDING, by classification of loan, at the end of months

сая.төг mln.tug

Хугацаа, сараар Periods, by months	Зээлийн өрийн үлдэгдэл Loans outstanding	Хэвийн зээл Standart loans	Хугацаа хэтэрсэн зээл Principal in arrears	Чанаргүй зээл Non performing laons				
					Төрийн салбар Public sector	Хувийн салбар Private sector	Иргэд Individuals	Бусад Other
<b>2016 он</b>								
2016 I	79,645.8	77,205.6	1,676.0	764.3	-	-	764.3	-
II	77,585.2	74,437.1	2,176.4	971.8	-	-	971.8	-
III	81,526.2	78,737.5	1,657.0	1,131.7	-	77.8	1,053.9	-
IV	82,634.2	79,841.3	1,587.9	1,204.9	-	144.8	1,060.1	-
V	80,354.1	77,419.5	1,505.4	1,429.3	-	117.7	1,311.6	-
VI	79,923.0	77,351.8	1,095.8	1,475.5	-	117.7	1,357.8	-
VII	79,463.2	76,561.1	1,284.6	1,617.5	-	117.7	1,499.8	-
VIII	83,764.1	81,063.2	1,083.8	1,617.1	-	117.7	1,499.4	-
IX	85,937.5	83,179.3	1,184.9	1,573.3	-	117.7	1,455.6	-
X	85,142.7	82,281.2	1,271.3	1,590.3	-	142.3	1,448.0	-
XI	-			-				
XII	-			-				

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО  
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Мян. төг <i>tous.tog</i>		
		Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
<b>ОРОН НУТГИЙН ОРЛОГО</b>		<b>58493638</b>	<b>52463384.0</b>	<b>89.7</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		5249998.4	4250084.9	81.0
Орлогын албан татвар		4071381.7	3378781.3	83.0
Хувь хүний орлогын албан татвар		4701381.7	4008781.3	85.3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		4410120.7	3756781.9	85.2
Үйл ажиллагааны орлого		116121.0	98289.2	84.6
Хөрөнгийн орлого		0.0	0.0	0.0
Хөрөнгө борлуулсны орлого		84000.0	74000.0	88.1
Шууд бус орлого		91140.0	79710.2	87.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-630000.0	-630000.0	100.0
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлого		0.0	0.0	0.0
Хөрөнгийн албан татвар		606444.0	462431.2	76.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		279774.0	160863.7	57.5
Бууны албан татвар		69270.0	56247.5	81.2
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		257400.0	245320.0	95.3
Бусад татвар, төлбөр, хураамж		572172.7	408872.4	71.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж		284550.1	232633.4	81.8
Улсын тэмдэгтийн хураамж		105237.6	86237.6	81.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		13390.0	8114.0	60.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж		165922.5	138281.8	83.3
Бусад татвар		0.0	0.0	0.0
Газрын төлбөр		206950.5	117778.0	56.9
Газрын төлбөр		206950.5	117778.0	56.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр		80472.1	58361.0	72.5
Ойн нөөц ашигласны төлбөр		2800.0	2250.0	80.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		77672.1	56111.0	72.2
Бусад татвар		200	102	51.0
Нохойны албан татвар		200	102	51.0
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>53243639.6</b>	<b>48213299.1</b>	<b>90.6</b>
Нийтлэг татварын бус орлого		798175.9	577680.5	72.4
Хүүгийн орлого		0	0	0.0
Торгуулийн орлого		401100	335115	83.5
Төсөв байгууллагын өөрийн орлого		113290	107227.4	94.6
Түрээсийн орлого		4203.2	3845.6	91.5
Бусад орлого		279582.7	131492.5	47.0
Хөрөнгийн орлого		20800	20800	100.0
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		0	0	0.0
Өмч хувьчлалын орлого		20800	20800	100.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		52424663.7	47614818.6	90.8
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		9600221.8	9016577	93.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		32241825.4	29441528.6	91.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		6569770.1	5671794.2	86.3
Эргэж төлөгдөх зээл		1303274.9	1210883.4	92.9
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		2274635.4	2274035.4	100.0

ТАТВАРЫН ОРЛОГО ГҮЙЦЭТГЭЛ, сумаар  
PERFORMANCE REVENUE *soum*

Мян.мөг tous.tog

№	Сум	Soum	Нийт орлого		
			Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	359,462.9	295,000.0	82.1
2	Алтай	<i>Altai</i>	14,294.4	11,512.4	80.5
3	Баян-Уул	<i>Bayn-Uul</i>	15,535.5	12,880.0	82.9
4	Бигэр	<i>Biger</i>	9,707.0	7,071.0	72.8
5	Бугат	<i>Bugat</i>	13,492.0	10,401.0	77.1
6	Дарив	<i>Dariv</i>	9,040.0	8,435.0	93.3
7	Дэлгэр	<i>Delger</i>	10,217.2	7,600.0	74.4
8	Жаргалан	<i>Jargalan</i>	10,329.5	9,433.2	91.3
9	Тайшир	<i>Taishir</i>	9,856.6	8,867.0	90.0
10	Тонхил	<i>Tonhil</i>	15,604.0	13,850.0	88.8
11	Төгрөг	<i>Tugrug</i>	13,191.0	9,068.0	68.7
12	Халиун	<i>Khaliun</i>	13,185.7	11,569.7	87.7
13	Хөхморьт	<i>Khukhmorit</i>	8,400.8	6,658.0	79.3
14	Цогт	<i>Tsogt</i>	17,020.4	14,270.4	83.8
15	Цээл	<i>Tseel</i>	12,346.0	11,700.0	94.8
16	Чандмань	<i>Chandmani</i>	13,802.5	12,295.0	89.1
17	Шарга	<i>Sharga</i>	10,502.0	8,610.0	82.0
18	Эрдэнэ	<i>Erdene</i>	11,200.6	10,313.6	92.1
19	Баянтоорой тосгон	<i>Bayntooroi</i>	7,436.0	6,345.0	85.3
20	Гуулин тосгон	<i>Guulin</i>	2,407.0	1,877.0	78.0
21	Татварын хэлтэс	<i>Straight communicant</i>	4,672,967.3	3,772,328.6	80.7
	<b>Дүн</b>		<b>5,249,998.4</b>	<b>4,250,084.9</b>	<b>81.0</b>

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА  
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

мян.төг, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>58,493,638.0</b>	<b>53,595,709.9</b>	<b>81.4</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	26,285,208.2	24,148,324.5	90.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,928,719.4	2,687,593.8	89.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,763,873.0	4,161,146.8	92.3
Хангамж бараа материалын зардал	1,179,851.1	1,102,933.1	88.0
Нормативт зардал	2,091,851.1	1,917,154.8	78.1
Эд хогшил, урсгал засварын зардал	589,668.7	586,237.1	83.0
Томилолт зочны зардал	305,339.0	279,961.5	81.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,628,651.4	1,596,905.1	57.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,388,639.2	1,349,907.0	85.5
ТАТААС	14,000.0	14,000.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,852,382.4	6,564,029.2	81.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,653,279.4	7,467,833.4	60.6
